

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	12
3.Менежментийн захидал.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	16
4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	18
4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Зорилтот түвшний гүйцэтгэл	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ДДЦС	Дарханы дулааны цахилгаан станц
ДҮТ	Дамжуулах үндэсний төв
ДДС	Дарханы дулааны сүлжээ
ХААН	Хөдөө аж ахуйн нэгдэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТГ-5	Трубин генератор 5 төсөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ М.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2020.03.13 № 06/835
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсээр хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлого, татварын суутган тооцоог зөв хийх, бараа ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зөв явуулах, бараа материал, үндсэн хөрөнгийг бүртгэлд зөв орлогодох, хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангуудад аудит хийлээ.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 24-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Дундманхайдай аудит ХХК-ийн аудитор Ж.Бямбажав, туслах аудитор З.Мандах нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайлангаа Дундманхайдай аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн эрхэм зорилго нь Дархан Сэлэнгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр, Дархан-Уул аймгийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах, хүний хөгжил болон хүний нөөцийг бүрэн дүүрэн ашиглах, санхүүгийн чадавхыг сайжруулахад оршино.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Тус цахилгаан станц нь хувьсах цахилгаан эрчим хүчийг боловсруулж, 6 киловольт хүчдэлийг 110/35 киловольтын түвшинд өсгөж агаарын шугамаар Эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдон Монгол Улс, Дархан-Уул аймгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамж, технологийн хэрэгцээний уураар хангадаг.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл нь:

- Цахилгаан үйлдвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Цахилгаанаар зохицуулалттай хангах
- Дулаанаар зохицуулалттай хангах
- Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг байна.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 01 сарын 24-ны 20 дугаар тогтоолоор худалдах дулааны тарифыг шинэчлэн баталсан,
- 2008 оны 5 дугаар сард Монгол улсын Засгийн газар, Холбооны бүгд найрамдах Герман улсын Сэргээн босголт Хөгжлийн банк хооронд 2007 онд байгуулсан Дархан дулааны цахилгаан станцын турбины шинэчлэх төслийн зээлийн хэлэлцээр"-ийг соёрхон батлан хэрэгжүүлснээр 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Турбины шинэчлэх төсөл бүрэн хэрэгжиж дууссан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 448 дугаар Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна. Тус баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байгаа ч тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зарим данстын төлөвлөгөөнд нэмэлт тодруулга шинэчлэл хийх шаардлагатай байна.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Интерактив би-ай” ХХК-ийн “Даймонд-5” программ хангамж ашигладаг ба цаашид тус программын шинэ хувилбар үүлэн систем нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал Аудитын явцад Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулга тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн батлагдсан зорилтот түвшний нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 43,949.2 сая төгрөгөөс тооцон 439.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцоолж 474.3 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,581.9 сая төгрөгөөр буюу 22.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/ Өөрчлөлт
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	234.2	203.8	(30.4)
Дансны авлага	2,037.9	3,483.4	1,445.5
Татвар, НДШ-ийн авлага	75.4	396.7	321.3
Бусад авлага	227.4	233.5	6.1
Бараа материал	3,641.6	4,379.0	737.4
Урьдчилж төлсөн зардал тооцоо	50,029.2	67,088.0	17,058.8
Эргэлтийн хөрөнгийн дүн	56,245.7	75,784.4	19,538.7
Үндсэн хөрөнгө	72,466.9	86,338.2	13,871.3
Биет бус хөрөнгө	22,849.4	23,021.2	171.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	95,316.3	109,359.4	14,043.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	151,561.9	185,143.8	33,581.9
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,545.2	7,334.5	3,789.3
Урт хугацаат өр төлбөрийн дүн	70,314.5	76,919.6	6,605.2
Өр төлбөрийн нийт дүн	73,859.7	84,254.1	10,394.5
Төрийн өмч	32,704.8	32,704.8	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	57,915.6	72,108.1	14,192.5
Хуримтлагдсан ашиг	(12,918.2)	(3,923.2)	8,995.0
Эздийн өмчийн дүн	77,702.3	100,889.7	23,187.4
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	151,561.9	185,143.8	33,581.9

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 30.4 сая төгрөгөөр буурсан нь харилцах банканд оны эхэнд төгрөгийн 15 данс, валютын 5 данстай 227.7 сая төгрөг үлдэгдэлтэй байснаас тайлант онд эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотойгоор оны эцэст 166.0 сая төгрөг болж буурсан байна.

Касс дахь үлдэгдэл өссөн нь Дарханы дулааны сүлжээ ТӨХК нь дулааны эрчим хүчний төлбөрийг оны эцэст 30.0 сая төгрөг касс бэлнээр тушаасан нь нөлөөлсөн байна.

Капитал банкны харилцах дансны 0.3 сая төгрөгийн үлдэгдлийг ХААН банканд төвлөрүүлсэн, Хас банканд цахилгааны орлого төвлөрүүлэлтийн данс шинээр нээгдсэн байна.

Нийт авлага оны эхэнд 2,340.6 сая төгрөг байснаас оны эцэст 4,113.6 сая төгрөг болж өмнөх оноос 1,772.9 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын авлага 1,445.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Энэ нь 2018-2019 онд шөнийн цахилгаан тарифыг тэглэсэн татаас санхүүжилт төсвөөс дутуу олгогдсон, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХК-иас авах цахилгааны авлага 1,368.1 сая төгрөгөөр, "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-иас авах дулааны авлага 77.4 сая төгрөгөөр, бусад авлага 327.4 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Бусад авлагын үлдэгдэлд он удаан жил болсон 2010 онд үүссэн 209.2 сая төгрөгийн "Дулаан шарын гол" ТӨХК-д хийсэн зуухны их засвар болон нийлүүлсэн материал сэлбэгийн үлдэгдэл тооцоог тайлант үед тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. 2020 онд энэ авлагыг хуулийн байгууллагад хандан холбогдох шийдвэрийг гаргуулан компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэхээр болсон байна. Бусад авлагаас үлдсэн 118.2 сая төгрөгийн авлага нэмэгдсэн өртгийн албан татварын суутган тооцооны авлага байна.

Урьдчилж төлсөн тооцооны үлдэгдэл 67,088.0 сая төгрөг байгаа нь 66,758.9 сая төгрөг нь Турбин генератор-5 төслийн гадаадын зөвлөх компанийн зардал, төслийн зургийн төлбөрийн тооцоо, 71.2 сая төгрөг нь 2019 онд ажил үйлчилгээ нь хийгдэж дуусаагүй дараа онд үргэлжилж байгаа хүчил төрөгчийн станцын шинэчлэлийн материал, хяналтын гэрээт ажлын урьдчилгаа, 257.9 сая төгрөг нь Шарын голын болон Багануурын уурхайн нүүрсний тээврийн зардлын урьдчилж төлөгдсөн зардал байна.

2019 оны эхэнд бараа материалын үлдэгдэл 3,641.6 сая төгрөг байсан бол оны эцэст 4,379.1 сая төгрөг болж 737.5 сая төгрөгөөр өссөн нь өвлийн ачааллын үед аваарын нөөц 25 хоног нүүрсний нөөцтэй байх шаардлагатай газар дээрх нүүрс, мазут бэлтгэсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны оны эцсийн нийт үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 13,871.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үед капиталжуулсан 2,421.6 сая мянган төгрөг, худалдан авснаас 3,533.7 сая төгрөг, данс хооронд шилжүүлж авсан 5,921.7 сая төгрөг, дуусаагүй барилга 1,008,5 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 131,045.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 28-ны 234 дүгээр тогтоолоор 1 тээврийн хэрэгсэл, 2 чиргүүлийг дуудлага худалдаагаар борлуулсан байна.

Их засварын түр данстуудын хөдөлгөөн болон данс хооронд шилжсэн хөдөлгөөнөөр 6,930.3 сая төгрөг нэмэгдэж, 5,672.4 сая төгрөг буурсан байна. 2019 оны эцэст дуусаагүй их засварын дансанд 1,257.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Өр төлбөр данс 2019 оны эхэнд 3,545.2 сая төгрөг байснаас оны эцэст 7,334.5 сая төгрөг болж 3,789.3 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд шөнийн тарифын цахилгааны авлагыг төсвөөс дутуу олгогдож эрчим хүчний салбар алдагдалтай ажилласнаас, компанийн борлуулалтын авлага оны эцэст 3,483.4 сая төгрөг болж 1,445.5 сая төгрөгөөр өсөж, борлуулалтын төлбөр дутуу хийгдсэн, 2019 онд уурхайнуудын нүүрсний үнэ 2000 төгрөгөөр нэмэгдэж, үйлдвэрлэлийн тарифт 560.0 сая төгрөгийн зохицуулалт хийгээгүйгээс нүүрсний төлбөрийг барагдуулаагүй зэргээс шалтгаалсан байна.

2018 оны 12 дугаар сарын 28-нд компанийн нүүрсний аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Хаан банкнаас нэг жилийн хугацаатай 1,000.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл авч 2019 онд графикт хугацаанд нь төлж барагдуулсан. 2019 онд борлуулалтын орлого цаг хугацаандаа орж ирэхгүй авлага үүссэнтэй холбоотойгоор ажилчдын цалинг хамтын гэрээнд заасан хугацаанд нь тавьж олгох зорилгоор ажлын 5 хоногийн хугацаанд хүүгүй нөхцөлтэй цалингийн зээл авч оны эцэст 380.5 сая төгрөгийн богино хугацаат зээлийн үлдэгдэл гарсан байна.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайланд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 61,107.6 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байна. Үүнд:

- ХБНГУ Сэргээн Босголтын Банкны 2018 онд Турбин-5 төслийн 56,453.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл, хүүгийн өглөг 2,506.1 сая төгрөг
- ХБНГУ Сэргээн Босголтын Банкны 2001-2028 онд хэрэгжих Дархан-1 төслийн 920.5 сая төгрөгийн зээл, 2005-2030 онд хэрэгжих Дархан-2 төслийн 467.5 сая төгрөгийн зээл
- ХБНГУ Сэргээн Босголтын Банкны 2001-2028 онд хэрэгжих Бараа төслийн 151.7 сая төгрөгийн зээл
- ХБНГУ Сэргээн Босголтын Банкны 2009-2030 онд хэрэгжих Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн багц-2,1 ТБЦДС ХК 578.6 сая төгрөгийн
- Азийн хөгжлийн банкны 2012-2031 Эрчим хүчний хэмнэлтийн өглөг УБДС 30.0 сая төгрөгийн зээл /Механик тоолуур электрон болж шинэчлэгдэн нарийвчлалын алдаа 2%-с 0.5% болж буурсан/

Эздийн өмч 2018 оны жилийн эцсээр ТӨБЗГ-аас газар эзэмших эрхийг үнэлж бүртгэлд тусгаснаар 32,704.8 сая төгрөг тайлагнасан, тайлант хугацаанд өөрчлөлт хийгдээгүй байна.

Хөрөнгийн дахин үнэлгээ 2019 онд 14,192.5 сая төгрөг болж өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэсэнтэй холбоотой.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 28 дугаар тушаалаар Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний

төлөвлөгөөг 43,949.2 сая төгрөгийн орлоготой, 43,949.2 сая төгрөгийн зардалтай, 0.00 төгрөгийн цэвэр ашиг, алдагдалтай ажиллахаар анх баталжээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 280 тоот тогтоолоор “ДДЦС” ТӨХК-ийн “Диспетчерийн үндэсний төв” ХХК-д худалдах цахилгааны тарифыг 2019 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн нэмэгдүүлэх шийдвэр гарсан тул 2019 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгон үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг 44,522.9 сая төгрөгийн орлоготой, 45,011.7 сая төгрөгийн зардалтай, 488.8 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны алдагдалтай ажиллахаар баталжээ.

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг 258.8 сая квт цаг төлөвлөснөөс 259.4 сая квт цаг түгээж зорилтот түвшнээс 579.3 мянган квт цаг илүү үйлдвэрлэж 100.2 хувь, дулааны эрчим хүчийг 532.6 сая Гкал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 537.8 сая. Гкал буюу 5.2 сая Гкал илүү түгээж 101.0 хувь тус тус биелүүлсэн байна. Дотоодын хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хувь 16.4 хувь болж төлөвлөснөөс 1.2 хувь буурсан байна.

2.Тус компанийн 2019 оны гол үзүүлэлтийг харьцуулж үзвэл:

Төлөвлөгөөгөөр 44,522.9 сая төгрөгийн борлуулалтын орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 44,637.5 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлж төлөвлөгөөг 114.6 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар давсан байна.

Борлуулалтын орлогын 41,444.3 сая төгрөг буюу 92.8 хувийг цахилгааны борлуулалтаас, 3,193.2 сая төгрөг буюу 7.2 хувийг дулааны борлуулалтаас төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны зардал 45,011.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 45,964.1 сая төгрөг зарцуулж 2.1 % буюу 952.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь тогтмол зардал 535.8 сая төгрөгөөр, түлшний зардал 416.6 сая төгрөгөөр тус тус тариф өссөнтэй холбоотой байна. Зардлын бүтцийг судалж үзвэл түлшний зардал 19,487.7 сая төгрөг буюу 42.4 %-г эзэлж, тогтмол зардал 26,479.5 сая төгрөг буюу 57.6 %-г эзэлж байна. Үндсэн үйлдвэрлэлийн зардлын 28,813.5 сая төгрөг буюу 62.7 хувь нь цахилгаанд, 17,150.6 сая төгрөг буюу 37.3 хувь нь дулаанд ноогдож байна.

Нийт үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөөр 488.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаас 1,326.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдал 952.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 1 тонн нүүрсний үнэ 2000 төгрөгөөр өссөн болон хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс элэгдэл, үл хөдлөх хөрөнгийн татвар, цалин нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 128.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 18.7 сая төгрөгийн алдаа залруулж, 1.7 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 107.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 109.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

- Үйлдвэрлэсэн кислородыг холбогдох бараа материалын дансанд 17.4 сая төгрөгийг орлогод тайлагнаагүй зардалд шууд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.",

13.1 -д."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцээгүй ба "Тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Ажиллагсдын цалинг тооцоходоо ХХОАТ-ын татварын хөнгөлөлтийг 1.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан

- Энх өлзий технологи ХХК-с худалдан авсан слюдагийн нэгжийн үнэ нь зах зээлийн үнээс өндөр нийт 1.7 сая төгрөг илүү байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;" гэсэн заалтуудтай нийцээгүй ба "Үнэлгээ", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэгжийн үнэ өндөр нийлүүлэгдсэн 1.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Аудитаар илэрсэн 107.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант оны аудитаар хамруулж амжаагүй дараагийн аудитад анхаарах асуудлуудыг дурдвал:

- НӨАТ-ийн өглөг 924.8 сая төгрөгөөр өнгөрсөн оноос өссөн нь гэрээгээр 19 компаниас 433.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн байгууллагууд нь НӨАТ төлөгч биш байгууллагуудаас нийлүүлэлт хийгдсэн нь өглөг бууруулах боломжийг алдсан байна. Иймд 2020 онд бараа үйлчилгээ нийлүүлэх компаниудыг сонгон шалгаруулахдаа" нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч" байх гэсэн шаардлага нөхцөлд хяналт хийх;
- Тус компани нь нягтлан бодох бүртгэлд зардлыг оновчтой ангилж хуримтлуулан бүртгэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг үнэн зөв, бодитой тооцоолсон, дотоод хяналттай холбоотой горимуудыг хэрэгжүүлж буй эсэх;
- Харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний биелэлт, гэрээг дүгнэж акт үйлдэж, үр дүнг тооцсон эсэхийг хамруулна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 48.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 109.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 474.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлого, НӨАТ-тай холбоотой асуудал

